

ДОРНОД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНЫ 07 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ
ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ АСУУДЛУУДЫН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022.08.01

Хэрлэн сум

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Цагдаагийн байгууллагад иргэд, хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2979 гомдол мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 473 буюу 18.8 хувиар өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 979 буюу 32.8 хувийг гэмт хэргийн шинжтэй, 200 буюу 68.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 07 дугаар сард 256 холбогдогчтой, 1050.1 төгрөгийн хохиролтой, 435 гэмт хэрэг бүртгэгдэж, 145 хэргээр буюу 50 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 32.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -3.6 хувиар буурчээ. Гэмт хэргийн улмаас 14 хүн нас барж, 164 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 2 буюу 16.6 хувиар өсч, гэмтсэн хүний тоо 44 буюу 36.6 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 271.4 төгрөг буюу 25.8 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн гаралт:-Хэрлэн сумын 1, 2, 4, 6, 7, 10, 11 дүгээ багууд, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот, Баянтүмэн, Гурванзагал, Чойбалсан, Булган, Хөлөнбуйр, Матад, Халхгол сумдуудад өсөж,

Хэрлэн сумын 3, 5, 8, 9 дүгээр багууд, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдад буурсан байна.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах 5 бүртгэгдэж 2 буюу 66.6 хувь, хүний амь насыг болгоомжгүй хохироох буюу 2 дахин, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 158 бүртгэгдэж 36 буюу 29.5 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, хулгайлах гэмт хэрэг 98 бүртгэгдэж 65 буюу 1.9 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, залилах гэмт хэрэг 60 бүртгэгдэж 29 буюу 93.5 хувь, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100%, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 2 буюу 100%, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 1 буюу 100 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 14 бүртгэгдэж 6 буюу 75.5 хувиар өсч

Хөрөнгө завших гэмт хэрэг 8 бүртгэгдэж 1 буюу 12.5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 11 бүртгэгдсэн 1 буюу 9 хувь, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж 3 буюу 25 хувь, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 10 бүртгэгдэж 2 буюу 20 хувь, хууль бусаар ан агнах 1 буюу 100 хувиар тус тус буурч

Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 5, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 3, гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 3, Мал хулгай гэмт хэрэг 34 бүртгэгдэж ижил түвшинд байна.

Хүүхдийн эсрэг, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, авлигын эсрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 98 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65 буюу 1.9 дахин өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 82 бүртгэгдэж 55 буюу 2 дахин өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 34 бүртгэгдэж ижил түвшинд байна. гэмт хэргийн илрүүлэлт 14.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн байна.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 90 бүртгэгдэж 42 буюу 87.5, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 33 бүртгэгдэж 21 буюу 1.7 дахин, Галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувь, хүүхэд оролцсон гэмт хэрэг 15 бүртгэгдэж 14 дахин тус тус өсөж

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 15, Мансуурсан үедээ үйдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 20 хүн холбогдсон нь 14 буюу 39.2 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж 5 буюу 35.1 хувиар тус тус буурсан

Үйлдэгдсэн газраар: - Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 42 бүртгэгдэж 5 буюу 13.5 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 32 бүртгэгдэж 25 буюу 3.5 дахин, Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 100%, Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг

21 бүртгэгдэж 3 буюу 16.3 хувь, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 30 бүртгэгдэж 8 буюу 36.6 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 33 бүртгэгдэж 11 буюу 50 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 106 бүртгэгдэж 49 буюу 85.6 тус тус өссөн байна.

Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 33.3 хувиар тус тус буурчээ.

Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь: 22-06 цагийн хооронд 145 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 32.7%, 06-14 цагийн хооронд 85 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 19.3%, 14-19 цагийн хооронд 137 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 31.4%, 19-22 цагийн хооронд 68 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 16.3%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 64 буюу 14.2 хувийг Даваа гарагт, 59 буюу 14.7 хувийг Мягмар гарагт, 59 буюу 15 хувийг Лхагва гарагт, 58 буюу 13.3 хувийг Пүрэв гаригт, 75 буюу 15 хувийг нь Баасан гарагт, 58 буюу 12.8 хувийг Бямба гарагт, 55 буюу 12.6 хувийг нь Ням гарагт тус тус үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг байршлаар нь. Чулуунхороот, Сэргэлэн, Хөлөнбуйр, Матад, Халх гол сумдад тус бүр 1 буюу 1.1 хувь, Хэрлэн сумын 3, 7-р баг, Чойбалсан, Баянтүмэн, Булган сумдад 2 буюу 2.2 хувь, Хэрлэн сумын 11-р баг, Баян-Уул, Гурванзагал сумдад 3 бүртгэгдэж 3 буюу 3.3 хувь, Баяндун, Дашбалбар сумдад 4 буюу 4.6 хувь, Хэрлэн сумын 1, 9 дүгээр багуудад 5 буюу 5.8 хувь, Хэрлэн сумын 4-р багт 6 буюу 6.9 хувь, Хэрлэн сумын 2-р багт 8 буюу 9.3 хувь, Хэрлэн сумын 10-р багт 12 буюу 13.9 хувь, Хэрлэн сумын 6-р багт 18 буюу 20.9 хувь бүртгэгдсэн байна.

Согтуугаар бүртгэгдсэн гэмт хэргийн 3 буюу 3.4 хувь нь хүнийг алах гэмт хэрэг, 60 буюу 69.7 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 1 буюу 1.1 хувь нь хүчиндэх, 9 буюу 10.4 хувь нь иргэдийн өмчийн хулгай, бусад төрлийн гэмт хэргүүд 13 буюу 15.1 хувийг эзлэж байна.

ХОЁР. ЗӨРЧИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны 7 дугаар сард 10911 зөрчил илрүүлсэн нь 2972 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 37,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 9809 иргэнийг 624857.5 төгрөгөөр торгож, 778 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 159 иргэний шүүгчийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлах шийтгэл оногдуулсан байна. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 1600 иргэнийг эрүүлжүүлсэн нь 299 буюу 22.9%-иар өссөн байна.

Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:

- | | |
|----------------------------------|----------------------------------|
| - Даваа гарагт 1673 буюу 14.9%, | - Баасан гарагт 1536 буюу 14.3%, |
| - Мягмар гарагт 1616 буюу 15.3%, | - Бямба гарагт 1340 буюу 12%, |
| - Лхагва гарагт 1654 буюу 14.9% | - Ням гарагт 1490 буюу 13.7 %, |
| - Пүрэв гарагт 1597 буюу 14.6%, | |
| - 06-12 цагт 1549 буюу 13.3 % | - 19-24 цагт 3402 буюу 29.4%, |
| - 13-18 цагт 5699 буюу 54.8%, | - 01-05 цагт 261 буюу 2.2%. |

Үйлдэгдсэн онцлогоор нь:

- | | |
|-----------------------------------|----------------|
| • Согтуугаар үйлдэгдсэн | 1001 буюу 8.3% |
| • Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 101 буюу 0.9% |
| • Эмэгтэй хүн оролцсон | 9 буюу 0.01% |
| • Харьяалалгүй иргэн | 0 буюу 0% |
| • Урьд ял шийтгэгдсэн | 0 буюу 0% |
| • Хүүхэд оролцсон | 1 буюу 0.001% |

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган 1600 иргэн саатуулагджээ. Үүний 100 буюу 6.2% нь эмэгтэй, 3 буюу 0.2% нь насанд хүрээгүй хүн эзлэж байна.

нийгмийн байдлаар нь:

- | | |
|-----------------------------|-----------------------------|
| • Ажилгүй | 1566 буюу 98.2% |
| • Төрийн албан хаагч | 7 буюу 0.4% |
| • Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 9 буюу 0.9% |
| • Ажилчин, малчин | 4 буюу 0.01% |
| • Бусад | 2 буюу 0.01%-г эзэлж байна. |

Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:

- | | |
|--|-----------------|
| • Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан | 1165 буюу 71.6% |
|--|-----------------|

- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 23 буюу 1.6 %
- Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон 62 буюу 3.8%
- Хаана байгаагаа, очих газраа мэдэхгүй болсон 41 буюу 2.8 %
- Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 276 буюу 17.1%
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 33 буюу 2.1%

Эрүүлжүүлэгдсэн газраар нь:

- **Гэр, орон сууцнаас 1234 буюу 76.6%**
- Гудамж талбайгаас 224 буюу 14.2%
- Байгууллага, аж ахуйн нэгжээс 45 буюу 2.8%
- Баар, цэнгээний газраас 35 буюу 2.1%
- Зочид буудлаас 38 буюу 2.6%.
- Бусад 24 буюу 1.5 % нь эрүүлжүүлэгджээ

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн 23.4%, зөрчлийн 46.3%-ийг согтуугаар, гэмт хэргийн 1 %, зөрчлийн 4.1%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

2. Нийт гэмт хэргийн 32.7 хувь нь 14-19 цагт, зөрчлийн 54.8% нь 13-18 цагт тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн 15% нь Баасан, Лхагва гарагт, зөрчлийн 15.3% нь тус бүр Мягмар гаригт үйлдэгджээ.

3. Гэмт хэргийн 34.1%, зөрчлийн 7.9%, саатуулсан хүний 76.6% нь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 69.7 % нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүлжүүлэгдсэн хүний 71.6%-ийг бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байгаа ба, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 1.2 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

5. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, залилах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, Хууль бусаар ашигт малтмал олборлох, эрүүл мэндийн эсрэг, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргүүд тус тус өссөн байна.

ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. 2022 оны эхний 7 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 20.6 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзлэж байна. Цаашид согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг өссөх хандлагатай байгаа тул урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, баг, сум хариуцсан алба хаагчид согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийг буруулах чиглэлээр нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.
2. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад 11 дахин хувиар өссөн байх тул гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад яриа таниулга хийж ажиллах.
3. Баг хариуцсан хэсгийн байцаагч нараас багийн хэмжээнд өссөн хэрэгт дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажлыг зөв оновчтой зохион байгуулах.
4. Залилах гэмт хэрэг 29 буюу 93.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иргэд олон нийтийн цахим хэрэглээ ихсэж онлайн хэлбэрээр бусдад залилуулах, хохирогч болох эрсдэлтэй байгаа тул энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээг зохион явуулах.
5. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 95.4 хувиар өссөнд дүн шинжилгээ хийхэд улс, аймгийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг цуцлаж, архи согтууруулах ундаагаар үйлчилгээ явуулдаг газруудын цагийн хуваарьт өөрчлөлт оруулсантайгаар холбоотойгоор иргэдийн хөдөлгөөн, архи согтууруулах ундааны хэрэглээ ихсэж архи согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын цагийн хуваарьт хяналт тавьж ажиллах.
6. Гудамж талбай, олон нийтийн газар, байгууллага аж ахуй нэгжүүдэд үйлдэгдсэн гэмт хэрэг 33.3-42.9 хувиар өссөн байгаад баг хариуцсан хэсгийн байцаагч нар анхаарч, зөрчлийн материал шалгах биш, хариуцсан багийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад онцгой анхаарч ажиллах.

Та бүхний ажилд амжилт хүсье.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР